



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 01 өдөр

Дугаар А/104

Сүхбаатар сум

### Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн бусдад шилжүүлэхээр хүсэлт гаргасан 2 иргэн, 1 аж ахуйн нэгжийн 2481 м<sup>2</sup> газрын эзэмших эрхийг хэзээр үлдээж, 4 иргэнд 728 м<sup>2</sup> газрыг анх олгосон хугацаагаар шилжүүлж хавсралтаар баталсугай.

2. Дээрх газарт кадастрын зураглал хийн хслбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож газар эзэмших эрх зүйн харилцаа үүсгэн, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3. Эзэмшил газраа зориулалтын дагуу ашиглаж арваас доошгүй хувьд ногоон байгууламж бүрдүүлэн, тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг хавсралтад дурдсан газар эзэмших эрх шилжүүлэгчдэд болон шилжүүлэн авагч иргэнд үүрэг болгосугай.

4. Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтад дурдсан нэр бүхий 2 шилжүүлэгчийн эзэмшилд олгосон аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/324, 2011 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/187, 2018 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн А/354 тоот захирамжийн холбогдох заалт, дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ш ОРГИЛ

